



2024 оны 5-р сарын 20
Утас: +976 7000-3437
Веб: <https://amcham.mn/publications/1>

Хэвлэлийн мэдээ
“Хиймэл оюун ухаан - бизнесийн салбарт үзүүлэх нөлөө”
сэдвээр АмЧам Монгол хэлэлцүүлэг зохион байгуулав

УЛААНБААТАР ХОТ, Монгол Улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2024 оны 5-р сарын 17-ны өдөр “Хиймэл оюун ухаан - бизнесийн салбарт үзүүлэх нөлөө” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав.

Бизнесийн салбарт хиймэл оюун ухааны үзүүлэх нөлөө, түүнийг зохицуулах бодлогын болон технологийн дэвшлийн талаар панелистуудын байр суурь, мэргэжлийн дүгнэлтүүдийг гишүүдтэй хуваалцав. Энэ удаагийн хуралд АмЧам Монголын гишүүн байгууллагуудын төлөөлөл болох Обортек компанийн гүйцэтгэх захирал Б. Тамир, Фаро Сангийн үүсгэн байгуулагч А. Бямбажаргал, ЛендМН компанийн дэд захирал Д. Баасандорж, Дэлхийн Банкны цахим эдийн засгийн бодлогын зөвлөх Б. Тэмүүлэн нар панелистуудаар уригдаж, АмЧам Монголын гүйцэтгэх захирал О. Адьяа хурлыг удирдан явуулав.

Дэлхийн Банкны цахим эдийн засгийн бодлогын зөвлөх Б. Тэмүүлэн хэлэхдээ “Хиймэл оюунд хөрөнгө оруулах нь хэрэглэгч нарын дижитал бичиг үсэг тайлагдахаас эхлэн технологийг хөгжүүлэгч хүртэл, нэмүү өртөг бүтээх бүх шат дамжлагт хүртээмжтэй байлгах нь Монголын ирээдүйн амжилтад онцгой ач холбогдолтой. Ногоон дата-төв, хиймэл оюун ухааны шийдлийг турших орчин зэрэг боломжууд нь Монгол улсад хиймэл оюун ухааныг нийгэм, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх хүчийг бий болгосноор стратегийн давуу талыг авчирна. Гэсэн хэдий ч үр өгөөжийг хүртээмжтэй, ёс зүйтэй, бидний соёлын үнэт зүйлс, урт хугацааны зорилгод нийцүүлэхийн тулд хүн төвтэй бодлогын тогтолцоог батлах нь маш чухал юм” гэж онцлов.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн Дэд сайд Б. Уянга онцлохдоо “Хөрш зэргэлдээх орнуудын тусгай хэрэгцээт болон тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нийт нутаг дэвсгэрийн 15 хүртэлх хувийг эзэлж байна. Харин Монгол Улсын хувьд энэ талбайн хэмжээ 76%-д хүрдэг. Бид хөрш зэргэлдээ орнуудаасаа яг юугаараа өөр вэ гэдэг нь тодорхойгүй байсаар байна” гэв. Мөн түүнчлэн “Хайгуулын үйл ажиллагаанаас ашиглалтын үйл ажиллагаа руу шилжих магадлал Монгол улсад 100-д 1 байгаа бол, дэлхийн ихэнх улсад 1000-д 1 байдаг. Иймд хайгуулын үйл ажиллагааг дэмжиж явуулснаар Монгол Улсын нутаг дэвсгэрийн хаана нь цаашдын уул уурхайн үйл ажиллагаа явагдах хэтийн төлөвийг мэдэж авна. Иймд бидний үйл ажиллагааг бүх нийтээр ойлгож хамтран ажиллах хэрэгтэй байна” хэмээв.

Обортек компанийн гүйцэтгэх захирал Б. Тамир онцлохдоо “AI хөгжүүлэлтийн тулгуур багана бол аливаа мэдээллийн чанартай холбоотой. Хиймэл оюунаас үнэн, бодит үр дүнд гаргаж авахын тулд үндсэн өгөгдлийн сан нь олон эх сурвалжаар баталгаажсан байх төдийгүй баттай хэрэгтэй.

Манай компани нь нийлүүлэлтийн сүлжээнд төвлөрсөн бус өгөгдөл баталгаажуулах платформыг санал болгодог. Оролцогч тал бүр блокчейн сүлжээгээр дамжуулан олон талын баталгаажуулсан

мэдээллийн санг бий болгож, талууд болон бизнес бүрт тохирсон хиймэл оюун ухааныг ашиглан бодит, оновчтой гарцыг санал болгодог” гэв.

Уулзалтын төгсгөлд АмЧам Монгол шинэ гишүүн “АВТ Associates” компанийг хүлээн авч, гишүүнчлэлийн сертификат гардуулав.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн Ази Номхон далайн 29 орны Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.